



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн
зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дондов овогтой Батзаяаг Австрали улсын “Charles Sturt” их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр магистрантурт 2 жил, Лүндээжанцан овогтой Мөнхдэмбэрэлийг Япон улсын Ази, Номхон Далайн их сургуулийн Ази, номхон далайн менежментийн чиглэлээр бакалаврын шатны сүүлийн 2 жил, Шийрэвдамба овогтой Маргадыг Австрали улсын “Macquarie” их сургуульд эдийн засгийн чиглэлээр магистрантурт 1 жилээр тус тус суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБЯАР